



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 376

Улаанбаатар хот

“Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг
шинэчлэн тогтоож, балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий прокурорын газрын харьяа Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой 6,666,667.00 (зургаан сая зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран долоо) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 5,000,000.00 (таван сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Хил хамгаалах ерөнхий газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн ерөнхий командлагч, Бригадын генерал Ж.Бямбасүрэн, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор, Хууль цаазын итгэмжит зөвлөх Г.Батбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001044
16-1 ruraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн
275 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРЫН ХАРЪЯА БАЙГУУЛЛАГЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, төрөл, Улсын болон арлын дугаар	Үйлдвэрлэгдсэн, ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, хуриутлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Автомашин эзэмшигч байгууллагын нэр	Автомашин хүлээн авагч байгууллагын нэр
3	Hyundai старекс (Хьюндай старекс) маркийн KMJWWN7HP6U699888 арлын, 4331ДГА улсын дугаартай суудлын автомашин	2006/2006	6,666,667.00	3	5,000,000.00	Дорноговь аймгийн Замын Үүд сум дахь Сум дундын прокурорын газар	Хил хамгаалах ерөнхий газар
НИЙТ ДҮН			6,666,667.00		5,000,000.00		
			(зургаан сая зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран долоон төгрөг)		(таван сая)		